

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН САРЫН МЭДЭЭ

2025 оны 05 дугаар сар

АГУУЛГА:

1. ДНБ
2. Гадаад худалдаа
3. Түүхий эдийн үнийн хандлага
4. УУ-н бүтээгдэхүүний биржийн арилжаа
5. Төлбөрийн тэнцэл, валютын нөөц
6. Инфляц
7. Төсөв
8. Мөнгө, санхүү
9. Хөдөлмөр
10. Аж ахуйн нэгж
11. Гадаад эдийн засаг – ОХУ, БНХАУ



ЭДИЙН ЗАСГИЙН ГОЛЛОХ ҮЗҮҮЛЭЛТҮҮД – 2025.05

ДНБ-ий өсөлт

(2025 оны 1 дүгээр улирал)

2.4 хувь

Гадаад валютын нөөц

(2025 оны 5 дугаар сар)

5,194 сая \$

Инфляц

(2025 оны 5 дугаар сар)

8.3 хувь

Төсвийн тэнц. тэнцэл

(2025 оны 5 дугаар сар)

-260 тэрбум ₮

Экспорт

(2025 оны 5 дугаар сар)

5,425 сая \$

Импорт

(2025 оны 5 дугаар сар)

4,540 сая \$

ГШХО

(2025 оны 1 дүгээр улирал)

666 сая \$

Зээлийн хүү

(2025 оны 5 дугаар сар)

17.2 хувь

Ажилчдын тоо

(2025 оны 1 дүгээр улирал)

1.38 сая

*1 улирлын байдлаар ажиллах хүчний оралцооны түвшин 62 хувь байна.

Бодит цалингийн өсөлт

(2025 оны 1 дүгээр улирал)

8.4 хувь

*ХҮИ 2015=100

Үйл ажиллагаа явуулж буй ААНБ

(2025 оны 1 дүгээр улирал)

109.8 мянга

*Худалдаа, үйлчилгээ, барилга, боловсруулах үйлдвэрлэлийн салбарууд давамгайлж байна.

Өрхийн бодит орлогын өсөлт

(2025 оны 1 дүгээр улирал)


5.8 хувь



Эдийн засгийн өсөлт 2025 оны эхний улиралд 2.4 хувьд хүрч удааширлаа. Үйлчилгээний салбарууд болон хөдөө аж ахуйн салбарын сэргэлт өсөлтийг дэмжсэн бол барилга, худалдаа, тээвэр, цэвэр татвар зэрэг салбарууд агшиж өсөлтийг сааруулав.

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ


(салбараар)

	2024I	2025I
ДНБ	7.9%	2.4%
Хөдөө аж ахуй	-24.8%	35.6%
Уул уурхай	13.3%	0.8%
Боловсруулах	4.9%	3.7%
Цахилгаан, ус	7.7%	5.5%
Барилга	27.7%	-1.1%
Бөөний болон жижиглэн худалдаа	6.0%	-5.8%
Тээвэр	26.9%	-21.6%
Мэдээлэл, холбоо	27.5%	16.5%
Үйлчилгээний бусад	3.4%	7.1%
Цэвэр татвар	13.1%	-2.3%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

УУЛ УУРХАЙ


(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

ХӨДӨӨ АЖ АХУЙ

(бодит ДНБ-ий хуримтлагдсан өсөлт, хувь)



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Бодит ДНБ 2025 оны эхний улиралд **2.4 хувиар өслөө.**
- Анхдагч салбар/Хөдөө аж ахуйн салбар 35.6 хувиар тэлж, өсөлтийн 1.0 нэгж хувийг, уул уурхайн салбар 0.8 хувиар тэлж, өсөлтийн 0.1 нэгж хувийг бүрдүүлэв.
- Хоёрдогч салбар/Боловсруулах, барилга, цахилгаан, усан хангамж/-ын үйлдвэрлэл 3.9 хувиар өсөж өсөлтийн 0.4 нэгж хувийг,
- Үйлчилгээний салбар/худалдаа, тээвэр, үйлчилгээний бусад/ 2.2 хувиар өсөж, өсөлтийн 1.2 хувийг бүрдүүллээ.
- Бүтээгдэхүүний цэвэр татвар 2.3 хувиар агшиж, өсөлтийг 0.4 нэгж хувиар бууруулав.
- Эдийн засгийн өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын сэргэлт болон үйлчилгээний бусад салбарын өсөлт голлон нөлөөлөв.
- Уул уурхай, боловсруулах, цахилгаан, усан хангамжийн салбарын үйлдвэрлэл нэмэгдэж, өсөлтөд эергээр нөлөөлж байна.
- Харин өмнөх оны суурийн нөлөөгөөр барилгын салбарын бүтээн байгуулалт буурсан бол нүүрс тээвэрлэгч аж ахуйн нэгжүүдийн орлого буурснаар тээврийн салбар агшив.
- Мөн хүнсний бус бүтээгдэхүүний худалдаа буурч, худалдааны борлуулалт агшив.
- Уул уурхайн салбар 2025 оны эхний улиралд 0.8 хувиар өслөө.
- Үүнд зэсийн баяжмал үйлдвэрлэл 448 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 29 хувиар өссөн нь голлон нөлөөлөв.
- Харин нүүрс, алт, газрын тос, төмрийн хүдэр зэрэг бүтээгдэхүүний үйлдвэрлэл 2025 оны эхний улиралд буурсан байна.
- Тухайлбал, нүүрс олборлолт 20 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувиар, төмрийн хүдэр 4 хувиар, газрын тос олборлолт 12 хувиар, алт олборлолт 9 хувиар тус тус буурав.
- ХАА-н салбар 2025 оны эхний улиралд 35.6 хувиар өслөө.
- Цаг агаарын нөхцөл байдал хэвийн байж, том малын зүй бус хорогдол өмнөх оны мөн үеэс 6.2 сая толгой малаар буурснаар сүүлийн 2 жил дараалан агшсан хөдөө аж ахуйн салбар сэргэв.

1.2 ХУДАЛДАН АВАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ИНДЕКС (PMI)2025 оны 1 дүгээр улирал


Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг илэрхийлдэг худалдан авалтын менежерийн индекс (PMI) 2025 оны эхний улиралд 51.2 хувь болж, 2 улирал дараалан буурлаа.

PMI
(50=өөрчлөлтгүй)




Эх сурвалж: Монголбанк

PMI, гол салбараар
(50=өөрчлөлтгүй)




Эх сурвалж: Монголбанк

PMI, аж ахуй нэгжийн төрлөөр
(50=өөрчлөлтгүй)



Эх сурвалж: Монголбанк

PMI, үзүүлэлтүүдээр
(50=өөрчлөлтгүй)



Эх сурвалж: Монголбанк


- Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн эдийн засгийн хүлээлтийг хэмждэг Худалдан авалтын менежерийн индекс (PMI) 2025 оны 1 дүгээр улиралд 51.2 хувь болж, өмнөх улирлаас 7.3 нэгж хувиар, өмнөх оны мөн үеэс 0.6 нэгж хувиар тус тус доогуур гарлаа.
- Сүүлийн 3 жилийн хандлагаар барилгаас бусад салбарын PMI эхний улиралд буурч байсан бол 2025 оны эхний улиралд бүх салбарын PMI буурлаа.
- Барилгын салбарын PMI хамгийн ихээр буюу 17.6 нэгж хувиар унаж, 7 дахь улиралдаа сөрөг хүлээлттэй байна.
- Үйлдвэрлэл, үйлчилгээний салбар эерэг хүлээлтээ хадгалсан бол худалдаа эрхлэгчдийн итгэл сөрөг төлөвт шилжсэн байна.
- 200-гаас дээш ажиллагсадтай том аж ахуй нэгжүүдийн PMI индекс 53.9 хувь болж, өмнөх улирлаас 9.3 нэгж хувийн огцом бууралт үзүүлэв.
- Харин 50-199 ажиллагсадтай дунд хэмжээтэй аж ахуй нэгжүүдийн PMI өмнөх улирлаас 5.5 нэгж хувиар буурч 44.6 хувь болсноор эргэн сөрөг төлөвт шилжив.
- Жижиг бизнесүүдийн PMI 6.5 нэгж хувиар буурч, 17 улирлын турш сөрөг хүлээлттэй байна.
- Хөдөлмөр эрхлэлтээс бусад бизнесийн үйл ажиллагааны хүлээлт өмнөх улирлын түвшнээс буурсан хэдий ч нийлүүлэлтийн хүргэлтийн хугацаанаас бусад хүлээлт эерэг хүлээлтийн бүсэд хадгалагдаж байна.
- Үйлдвэрлэлийн хэмжээний PMI өмнөх улиралд 8.8 нэгж хувиар буурсан бол энэ улиралд дахин 10.6 нэгж хувиар уналаа.



Эрэлт талаас эдийн засгийн өсөлтийг өрхийн хэрэглээ болон нийт хөрөнгө оруулалт голлон дэмжлээ.

ДНБ-ий өсөлт


(жилийн өсөлтийн хувь)



- Эдийн засгийн өсөлтийг дотоод эрэлт голлон дэмжив. Нийт өсөлтийн 9.9 нэгж хувийг үндсэн хөрөнгийн хуримтлал, 9.6 нэгж хувийг өрхийн хэрэглээ бүрдүүлсэн байна.
- Харин цэвэр экспорт өсөлтийг 14.9 нэгж хувиар бууруулсны 11.6 нэгж хувийг экспортын бууралт, 3.3 нэгж хувийг импортын өсөлт бүрдүүлсэн байна.

ТӨРИЙН БОЛОН ӨРХИЙН ХЭРЭГЛЭЭНИЙ ӨСӨЛТ

(жилийн өсөлтийн хувь)



- Төрийн хэрэглээ бодит дүнгээр өмнөх оны мөн үеэс 5.5 хувиар буурсан бол өрхийн хэрэглээ 11.9 хувиар өсөв.

ХӨРӨНГИЙН ХУРИМТЛАЛЫН ӨСӨЛТ

(жилийн өсөлтийн хувь)



- Үндсэн хөрөнгийн хуримтлал 30.4 хувиар өсөхөд малын зүй бус хоргодол 6.2 сая толгойгоор буурч, биологийн өсөж үрждэг хөрөнгийн нөөц нэмэгдсэн нь голлон нөлөөллөө.

ЭКСПОРТ, ИМПОРТЫН ӨСӨЛТ

(жилийн өсөлтийн хувь)




- Бараа, үйлчилгээний экспорт өмнөх оноос 18 хувиар буурсан бол бараа, үйлчилгээний импорт 2.9 хувиар өслөө.




Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэл 2025 оны эхний 5 сард 0.6 хувиар буурсан байна. Уул уурхайн салбарт нүүрс, алт, газрын тос олборлолтын биет хэмжээ өмнөх оны мөн үеэс буурав.

НИЙТ ҮЙЛДВЭРЛЭЛ
(тэрбум төгрөг)



- Аж үйлдвэрийн салбарын үйлдвэрлэл 2025 оны эхний 5 сард 15.5 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 0.6 хувиар буурсан байна.
- Зэсийн баяжмалын үйлдвэрлэл өссөн ч нүүрсний үйлдвэрлэл буурснаар уул уурхайн салбарын үйлдвэрлэл нэрлэсэн дүнгээр 4.6 хувиар буурлаа.
- Боловсруулах салбарын нийт үйлдвэрлэл (нэрлэсэн дүнгээр) 2025 оны эхний 5 сард 5.7 хувиар өсөхөд хүнсний бүтээгдэхүүн, ундаа үйлдвэрлэл болон химийн бодисын үйлдвэрлэл нэмэгдсэн нь нөлөөлөв.

НҮҮРС ОЛБОРЛОЛТ
(сая тонн)



- Аж үйлдвэрийн салбарын нийт үйлдвэрлэлийн 70 орчим хувийг* уул уурхайн салбар, түүн дотор 43 хувийг нь нүүрсний олборлолт эзэлдэг.
- Нүүрсний олборлолт 2025 оны эхний 5 сард 38.0 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хувиар буурсан байна. 2025 оны 5 дугаар сарын дүнгээр нүүрс олборлолт 0.4 хувиар өсөлттэй байна.

*2024 оны байдлаар


УУЛ УУРХАЙН ОЛБОРЛОЛТ
(голлох бүтээгдэхүүнээр)

		ӨМНӨХ ОНООС ӨӨРЧЛӨЛТ:
Зэсийн баяжмал	801 мян.тонн	30.9%
Газрын тос	1.6 сая баррель	-11.9%
Алт	3.5 тонн	-16.7%
Төмрийн хүдэр	3.5 сая тонн	0.3%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

- Оюутолгойн зэсийн баяжмалын үйлдвэрлэл нэмэгдсэнээр 2025 оны эхний 5 сард нийт зэсийн баяжмалын үйлдвэрлэл 31 хувиар өсөж 801 мянган тоннд хүрэв.
- Төмрийн хүдэр, төмрийн хүдрийн баяжмал үйлдвэрлэл 3.5 сая тоннд хүрч, 0.3 хувиар өссөн байна.
- Харин алт болон газрын тос олборлолт өмнөх оны мөн үеийн үйлдвэрлэлийн түвшнээс доогуур хэвээр байна.


ҮЙЛДВЭРЛЭГЧИЙН ҮНИЙН ИНДЕКС (2015=100)




- Үйлдвэрлэгчийн үнийн индекс 2025 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 2.1 хувиар буурсан байна.
- Үнэ өссөн:
 - Хүнсний бүтээгдэхүүний үйлдвэрлэл 7.5 хувиар;
 - Ундаа үйлдвэрлэл 6.9 хувиар;
 - Тавилгаас бусад мод, модон бүтээгдэхүүн үйлдвэрлэл 88.1;
 - Цахилгаан, хий, уур, агааржуулалт 54.5 хувиар тус тус өссөн бол
- Үнэ буурсан:
 - Нүүрс олборлолт 20.1 хувиар;
 - Газрын тос олборлолт 1.8 хувиар
 - Төмөрлөг бус эрдэс бодисоор хийсэн үйлдвэрлэл 1.5 хувиар тус тус буурсан байна.




Боловсруулах салбарын үйлдвэрлэл 2025 оны эхний 5 сард үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан бодит дүнгээр 0.3 хувиар буурав. Хөдөө аж ахуйн гаралтай сүү, гурил, ноолуур, арьс шир зэрэг бүтээгдэхүүнүүдийн үйлдвэрлэлийн биет хэмжээ буурлаа.




- Боловсруулсан малын мах 2025 оны эхний 5 сард 11.6 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 20 хувиар буурлаа.
- Боловсруулсан нийт махны биет хэмжээ буурсан ч үхэр, адууны махны боловсруулалтын хэмжээ өмнөх оноос 25 хувь, 23 хувиар тус тус нэмэгдсэн нөлөөгөөр боловсруулах үйлдвэрлэлийн 8-10 орчим хувийг бүрдүүлдэг мах боловсруулах, консервлох үйл ажиллагааны бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 1.6 хувиар өслөө.



- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 5 сард 64 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 3.0 хувиар буурсан байна.
- Гурилын үйлдвэрлэлийн биет хэмжээ буурсан голлох нөлөөгөөр боловсруулах салбарын 5-7 орчим хувийг бүрдүүлдэг үр тарианы гурилын болон цардуул, цардууллаг бүтээгдэхүүний бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 10.2 хувиар буурлаа.



- Согтууруулах болон согтууруулах бус ундаа үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 5 сард 235 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 1.2 хувиар өслөө.
- Үйлдвэрлэлийн биет хэмжээ өссөн нөлөөгөөр боловсруулах салбарын 20-25 орчим хувийг бүрдүүлдэг ундааны бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оны мөн үеэс 1.8 хувиар өслөө.




- Самнасан ноолуурын үйлдвэрлэл 2025 оны эхний 5 сард 273 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 25 хувиар өслөө.
- Ноолуурын үйлдвэрлэлийн биет хэмжээний өссөн хэдий ч боловсруулах салбарын 3-5 орчим хувийг бүрдүүлдэг нэхмэлийн бодит үйлдвэрлэл (үйлдвэрлэгчийн үнийн индексээр засварласан) өмнөх оноос 17 хувиар буурсан байна*.


*Ноолууран сүлжмэл эдлэлийн биет хэмжээний бууралт голлон нөлөөлөв.




Барилгын салбарын дотоодын үйлдвэрлэлийн голлох орц болох цемент болон вакум цонх, хаалганы үйлдвэрлэл нэмэгдэж, метал бэлдэц, метал цувималын үйлдвэрлэл бууралттай хэвээр байна.




■ Цемент үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 5 сард 535 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 9.6 хувиар өссөн байна.



■ Катодын зэс үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 5 сард 3,192 тонн болж, өмнөх оны мөн үеэс 8.4 хувиар буурлаа.



■ Метал бэлдэц болон цувимал бүтээгдэхүүний үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 5 сард 31.7 мянган тонн болж, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар буурлаа.



■ Вакум цонх, хаалганы үйлдвэрлэлийн биет хэмжээ 2025 оны эхний 5 сард 11.8 мянган м2 болж, өмнөх оны мөн үеэс 21.4 хувиар өслөө.



Төмөр замын ачаа тээвэр эхний 5 сарын байдлаар нүүрс болон газрын тосны олборлолт буурсантай холбоотойгоор 5 хувиар буурав. Худалдан авалтын идэвх саарч, худалдаа, зочид буудал, нийтийн хоолын салбарын бодит орлого буурсан үзүүлэлттэй байна.



- Үйлчилгээний салбарын дийлэнхийг бөөний болон жижиглэн худалдааны салбар бүрдүүлдэг.
- Тус салбарын борлуулалтын орлого 2025 оны эхний 4 сард нэрлэсэн дүнгээр 19.1 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.4 хувиар, үнийн нөлөөг засварласан бодит орлогын дүнгээр 7.7 хувиар буурсан байна.



- Зочид буудал болон нийтийн хоолны салбарын борлуулалтын орлого 2025 оны эхний 4 сард нэрлэсэн дүнгээр 11 хувь болон 9 хувиар тус тус өссөн байна.
- Харин инфляц эрчимжсэнээр үнийн нөлөөг засварласан зочид буудлын салбарын бодит орлогын дүн 5 хувиар, нийтийн хоолны салбарын бодит орлогын дүн 7 хувиар буурсан байна.



- Төмөр замаар 2025 оны эхний 5 сард 17.3 сая тонн ачаа тээвэрлэсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5 хувиар буурсан байна. Үүнд, нүүрс болон нефтийн бүтээгдэхүүний тээвэр буурсан нь гол нөлөөлөв.
- Агаараар тээвэрлэсэн ачаа өмнөх оны мөн үеэс 2 хувиар өссөн байна.
- Авто замаар 2025 оны эхний улиалд 18.2 сая тонн ачаа тээвэрлэж, өмнөх оны мөн үеэс 2 хувиар нэмэгдэв.




- 2025 оны эхний 5 сард Монгол Улсын хилээр орсон жуулчдын тоо 220.1 мянгад хүрч, өмнөх оны мөн үетэй харьцуулахад 23.4 хувиар өссөн байна.

*МЯНГАН ТОНН



2025 оны эхний 5 сарын байдлаар гадаад худалдааны бараа эргэлт 10.0 тэрбум ам.долларт хүрсэн бол худалдааны тэнцэл 885 сая ам.долларын ашигтай гарлаа.


ЭКСПОРТ
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Экспорт 2025 оны 5 дугаар сарын байдлаар 5,425 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 15 хувиар буурлаа.
- Нийт экспортын 95 хувийг уул уурхайн бүтээгдэхүүн бүрдүүлээ.


ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ЭКСПОРТ (сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- Нүүрсний экспортын орлого 2,283 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 41 хувиар буурлаа.
- Зэсийн баяжмалын экспортын орлого 1,853 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 61 хувиар өслөө.
- Алтны экспортын орлого 331 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1 хувиар буурлаа.
- Төмрийн хүдрийн экспортын орлого 221 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 7 хувиар буурлаа.


ИМПОРТ
(сая ам.доллар)



Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар

- 2025 оны 5 дугаар сарын байдлаар импорт 4,540 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 3.3 хувиар өссөн байна.
- Нийт импортын 18 хувийг тоног төхөөрөмж, 17 хувийг нефтийн бүтээгдэхүүн, 12 хувийг суудлын автомашин эзэлж байна.
- Нийт импортын өсөлтөд суудлын автомашины импортын өсөлт голлох нөлөөг үзүүлээ.

ГОЛЛОХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ
ИМПОРТ (сая ам.доллар)




Эх сурвалж: Гаалийн ерөнхий газар


- Нефтийн бүтээгдэхүүний импорт 764 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 7.5 хувиар буурлаа.
- Тоног төхөөрөмжийн импорт 827 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар буурлаа.
- Суудлын автомашины импорт 561 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 46.4 хувиар өслөө.
- Барилгын материалын импорт 515 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 14.0 хувиар өслөө.




2025 оны 5 дугаар сарын байдлаар уул уурхайн бүтээгдэхүүн нийт экспортын 95 хувийг бүрдүүллээ.




- Нүүрсний экспортын биет хэмжээ 2025 оны эхний 5 сард 31.8 сая тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 2.3 хувиар буурлаа.



- Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ 2025 оны эхний 5 сард 852 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 32.5 хувиар өслөө.




- Төмрийн хүдрийн экспортын биет хэмжээ 2025 оны эхний 5 сард 3,107 мянган тоннд хүрч, өмнөх оны мөн үеэс 5.0 хувиар өслөө.




- Газрын тосны экспортын биет хэмжээ 2025 оны эхний 5 сард 1,464 мянган баррельд хүрч, өмнөх оны мөн үеэс 16.6 хувиар буурлаа.




2025 оны эхний 5 сард голлох хөдөө аж ахуйн бүтээгдэхүүнүүдийн экспорт өмнөх оны мөн үеэс буурлаа.




■ Малын махны экспорт 2025 оны эхний 5 сард 47 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 32 хувиар буурлаа.



■ Боловсруулсан арьс ширний экспорт 2025 оны эхний 5 сард 485 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 69 хувиар буурлаа.



■ Ноолуурын экспорт 2025 оны эхний 5 сард 25 сая ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 74 хувиар буурлаа.



■ Ноосны экспорт 2025 оны эхний 5 сард 720 мянган ам.долларт хүрч, өмнөх оны мөн үеэс 9 хувиар өслөө.



ДЭЛХИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭЭРХ
ТҮҮХИЙ ЭДИЙН ҮНИЙН ХАНДЛАГА

НҮҮРС

(\$/тонн, Сингапурын бирж дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрс)



Эх сурвалж: Блүүмберг

- Сингапурын бирж (SGX) дэх Австралийн сайн чанарын коксжих нүүрсний 2025 оны 5 дугаар сарын дундаж үнэ 181 ам.долларт хүрч, өмнөх сараас 3 хувиар, өмнөх оны мөн үеэс 27 хувиар буурсан байна.

ЗЭС

(\$/тонн , Лондоны металлын бирж дэх цэвэр зэс)




Эх сурвалж: Блүүмберг

- Лондоны металлын бирж (LME) дэх цэвэр зэсийн үнэ 2025 оны 5 дугаар сарын дунджаар 9,757 ам.доллар хүрч өмнөх оны мөн үеэс 1 хувиар өссөн байна.

ТӨМРИЙН БАЯЖМАЛ

(\$/тонн, Зүүнхойд Хятад дахь 62 хувийн агууламжтай төмрийн баяжмал)




Эх сурвалж: Блүүмберг

- Зүүн хойд Хятад дахь төмрийн баяжмалын 2025 оны 5 дугаар дундаж үнэ 94 ам.долларт хүрч, өмнөх сараас 4 хувиар, өмнөх оны мөн үеэс 12 хувиар буурсан байна.

ГАЗРЫН ТОС

(\$/баррель, Brent)



Эх сурвалж: Блүүмберг

- Бrent газрын тосны 2025 оны 5 дугаар сарын дундаж үнэ 69 ам.долларт хүрч өмнөх сараас 9 хувиар буурсан хэдий ч өмнөх оны мөн үеэс 10 хувиар өслөө.



Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 2025 оны эхний 5 сард 2.1 мянган тонн нүүрс, 2.8 сая тонн төмрийн хүдэр болон баяжмал, 11.6 мянган тонн жоншны баяжмал, 13.6 мянган тонн зэсийн баяжмал арилжаалаад байна.



- 2025 оны 5 дугаар сарын байдлаар 2023 оноос хойш нийт 39.4 сая тонн нүүрс арилжиж, 4.7 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Үүнээс 2024 онд 22.4 сая тонн нүүрс арилжиж, 2.4 тэрбум ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 5 сард 2.1 сая тонн нүүрс борлууллаа.



- 2025 оны 5 дугаар сард нүүрсний дуудах дундаж үнэ 83 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 89 ам.доллар байв.
- Нүүрсний төрлөөс хамааран 5 дугаар сард хэлцлийн доод үнэ 84 ам.доллар, дээд үнэ 93 ам.долларт хүрэв.



- 2025 оны 5 дугаар сарын байдлаар 2023 оны 9 дүгээр сараас хойш нийт 5.9 сая тонн төмрийн хүдэр арилжиж, 397 сая ам.долларын орлого олжээ
- Үүнээс 2024 онд 2.4 сая тонн төмрийг арилжаалж, 167 сая ам.долларын орлого олжээ.
- Харин 2025 оны эхний 5 сард 2.8 сая тонн төмрийн хүдэр борлууллаа.




- Төмрийн хүдэр болон баяжмалын 5 дугаар сарын дуудах дундаж үнэ 61 ам.доллар, хэлцлийн дундаж үнэ 64 ам.доллар ам.доллар байв.
- Төмрийн төрлөөс хамааран 5 дугаар сард хэлцлийн доод үнэ 59 ам.доллар, дээд үнэ 79 ам.долларт хүрэв.

5. ТӨЛБӨРИЙН ТЭНЦЭЛ, ГАДААД ВАЛЮТЫН НӨӨЦ


2025.04-05 сар




Төлбөрийн тэнцэл 2025 оны эхний 4 сард 491 сая ам.долларын алдагдалтай гарлаа. Гадаад валютын улсын нөөц 2025 оны 5 дугаар сарын эцэст өмнөх сараас 58 сая ам.доллараар нэмэгдлээ.




- Төлбөрийн тэнцэл 2025 оны 4 дүгээр сарын байдлаар 491 сая ам.долларын алдагдалтай байна.
- Өмнөх оны мөн үетэй харьцуулахад урсгал дансны алдагдал 316 сая ам.доллараар, санхүүгийн дансны ашиг 226 сая ам.доллараар тус тус их байна.



- Гадаад валютын улсын нөөц 2025 оны 5 дугаар сарын эцэст 5,194 сая ам.доллар болж, өмнөх сараас 58 сая ам.доллараар, өмнөх оны мөн үеэс 10 сая ам.доллараар тус тус өссөн байна.



- Төгрөгийн ам.доллартой харьцах ханш 2025 оны 5 дугаар сард өдөрт дунджаар 0.1 төгрөгөөр суларч, сарын эцэст 3,574 төгрөгт хүрлээ.



- Төв банк 2025 оны 5 дугаар сард нийт 400 сая ам.долларыг зах зээлд нийлүүллээ.
- Төв банк 2025 оны эхний 4 сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 22.1 хувиар буюу 541 сая ам.доллараар их 3.0 тэрбум ам.долларыг дуудлага худалдаагаар зах зээлд нийлүүлээд байна.


*Нийт хөрөнгө оруулалтаас хөрөнгө оруулалтын буцаалт болон зээлийн эргэн төлөлтэй холбоотой гарах урсгалыг хассан дүн




Инфляц 2025 оны 5 дугаар сард 8.3 хувьд хүрч, өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурлаа. Инфляц өмнөх сараас 0.3 нэгж хувиар буурахад махны үнийн өсөлт саарсан нь голлон нөлөөлжээ. Нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сартай харьцуулахад 0.2 хувиар өссөн байна.




- Инфляц 2025 оны 5 дугаар сард улсын хэмжээнд 8.3 хувь гарлаа.
- Импортын гаралтай инфляц нийт инфляцын 2.3 нэгж хувь (27.9 хувь)-ийг бүрдүүлж байна.
- Дотоодын бараа, үйлчилгээний үнийн өсөлт нийт инфляцын 6.0 нэгж хувь буюу 72.1 хувийг эзэлж байна.



- 2025 оны 5 дугаар сард нийт бараа, үйлчилгээний үнэ өмнөх сараас 0.2 хувиар өсөв.
- Үүнд мах, махан бүтээгдэхүүний үнэ өмнөх сараас 1.0 хувиар, хүнсний ногооны үнэ 4.7 хувиар өссөн нь голлон нөлөөлсөн байна.



- Суурь инфляц нь нийт инфляцаас хүнс, шатахуун, хатуу түлшний үнийг хасаж тооцсон эрэлтийн гаралтай инфляц юм.
- 2025 оны 5 дугаар сард суурь инфляц 9.1 хувь гарч, нийт инфляцын 5.6 нэгж хувийг бүрдүүлж байна.
- Суурь инфляц сүүлийн 2 сар дараалан буурсан үзүүлэлттэй байна.



- Мах, сүү, гурил зэрэг голлох бүтээгдэхүүнүүдийн үнийн өсөлт 2025 оны 5 дугаар сард жилийн инфляцын 9.7 хувийг бүрдүүлж байна.
- Гурил, гурилан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 1.5 хувиар буурлаа.
- Сүү, сүүн бүтээгдэхүүн, өндөгний үнэ өмнөх оны мөн үеэс 1.1 хувиар өслөө.
- Хонины махны үнэ өмнөх оны мөн үеэс 7.9 хувиар өслөө.



Олон улсад чингэлэг тээврийн үнэ өмнөх сараас 59 хувиар өслөө. Хүнсний үнийн индекс 2025 оны 5 дугаар сард өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өссөн үзүүлэлттэй байна.



- Хүнсний инфляц 2025 оны 5 дугаар сард 5.5 хувь болж, нийт инфляцын 1.6 нэгж хувийг бүрдүүлэв. Хүнсний инфляц саарахад мах, махан бүтээгдэхүүн, гурил, гурилан бүтээгдэхүүний үнийн өсөлт саарсан нь нөлөөлжээ.
- Хүнсний бус инфляц 9.4 хувь болж, нийт инфляцын 6.7 нэгж хувийг бүрдүүллээ.



- Төгрөгийн амдоллартой харьцах ханш 2025 оны 5 дугаар сард дунджаар 3,573 төгрөг болж, өмнөх сараас 0.9 хувиар сулав.
- Импортын бараа бүтээгдэхүүний үнэ 2024 оны 5 дугаар сарын байдлаар өмнөх сараас 0.1 хувиар өслөө.




- Дэлхийн чингэлэг тээврийн үнэ нэмэгдлээ. Үүнд АНУ-ын ерөнхийлөгч Доналд Трампын тарифын “түр зогсолт”-оос үүдэлтэйгээр Номхон далайн тээврийн хэмжээ эргэн сэргэсэн нь нөлөөллөө.
- Чингэлэг тээврийн үнэ (Drewry World Container Index) 2025 оны 6 дугаар сарын 12-ны өдрийн байдлаар 40 фут контейнер тутамд 3,543 ам.доллар болж, өмнөх сараас 59 хувиар өссөн байна.
- Чингэлэг тээврийн үнэ өсөж байгаа нь нийлүүлэлтийн гаралтай инфляцын дарамтыг нэмэгдүүлж байна.



- НҮБ-ийн Хүнс, хөдөө аж ахуйн байгууллагаас зарладаг дэлхийн хүнсний үнийн индекс хүнсний барааны 5 бүлгийн дундаж үнийн сар бүрийн өөрчлөлтийг харуулдаг.
- Хүнсний үнийн индекс 2025 оны 5 дугаар сард 127.7 болж, өмнөх оны мөн үеэс 6.0 хувиар өссөн бол өмнөх сараас 0.8 хувиар буурсан байна.
- Сүүлийн сард дэлхийн зах зээл дээр сүүн бүтээгдэхүүн болон махны үнэ өссөн бол үр тариа, элсэн чихэр, ургамлын тосны үнэ буурсан байна.



Төсвийн нийт орлого 2025 оны эхний 5 сарын байдлаар 11.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.3 их наяд төгрөг буюу 10.6 хувиар буураад байна. Төсвийн орлого өмнөх оны мөн үеэс буурахад түүхий эдийн үнийн уналт голлон нөлөөлсөн байна.




- Төсвийн нийт орлого ба тусламжийн дүн 11.4 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 1.3 их наяд төгрөг буюу 10.6 хувиар буурсан байна.
- Дээрх бууралтад ААНОАТ 660 тэрбум төгрөг буюу 23.3 хувиар, нийт АМНАТ-ийн орлого 1,353 тэрбум төгрөгөөр буюу өмнөх оноос 55.2 хувиар буурсан нь голлон нөлөөлсөн байна.



- Төсвийн зарлага 2025 оны 5 дугаар сарын байдлаар 11.0 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 928 тэрбум төгрөг буюу 9.2 хувиар нэмэгдсэн байна.
- Төрийн албан хаагчдын цалин хөлс болон тэтгэвэр, тэтгэмжийг 2025.01.01-ний өдрөөс өмнөх оны инфляцын түвшинд уялдуулан 6.0 хувиар нэмэгдүүлсэн.
- Цалингийн хөлс болон нэмэгдэл урамшууллын зардал 2.6 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 30.0 хувиар, тэтгэвэр, тэтгэмж 3.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 16.8 хувиар тус тус өссөн байна.




- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл 2025 оны 5 дугаар сарын байдлаар 260 тэрбум төгрөгийн алдагдалтай гарч, өмнөх оноос 2.3 их наяд төгрөгөөр буурлаа.
- Нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл алдагдалтай гарахад нүүрсний үнийн бууралт болон ААНОАТ-ын орлого багассантай холбоотойгоор төсвийн орлого төвлөрүүлэлт саарсан нь голлох нөлөө үзүүллээ.



- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдэл 2025 оны эхний улиралд 34.6 их наяд төгрөгт хүрч, ДНБ-д эзлэх хувь 37.3 хувьд хүрээд байна.
- Засгийн газрын өрийн нэрлэсэн үлдэгдлийг ДНБ-д харьцуулсан харьцаа хуульд заасан тусгай шаардлагыг хангаж байна.



Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 5 дугаар сарын байдлаар өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өсөж, 41.5 их наяд төгрөгт хүрлээ. Банкны салбарын зээлийн үлдэгдэл 2025 оны 5 дугаар сард 40.3 их наяд төгрөгт хүрч, жилийн өсөлт 29.5 хувьд хүрлээ.



- Мөнгөний нийлүүлэлт 2025 оны 5 дугаар сарын эцэст 41.5 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.3 хувиар өссөн байна.
- Төгрөгийн хадгаламж нийт өсөлтийн 8.7 нэгж хувь, төгрөгийн харилцах -0.2 нэгж хувь, гадаад валютын хадгаламж 2.3 нэгж хувь, гадаад валютын харилцах -4.5 нэгж хувийг тус тус бүрдүүлсэн байна.



- Нийт хадгаламж 27.5 их наяд төгрөгт хүрч хүрч, өмнөх оны мөн үеэс 18.5 хувиар өслөө.
- Төгрөгийн хадгаламж 22.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 18.0 хувиар, өмнөх сараас 1.3 хувиар тус тус өслөө.
- Гадаад валютын хадгаламж 5.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 20.8 хувиар, өмнөх сараас 1.1 хувиар тус тус өсөв.



- Банкнуудын зээлийн үлдэгдэл 2025 оны 5 дугаар сарын эцэст 40.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 29.5 хувиар өслөө.
- Нийт зээлийн үлдэгдэлд эзлэх чанаргүй зээлийн хувь хэмжээ 5.3 хувь болж, өмнөх оны мөн үеэс 1.0 нэгж хувиар буурсан байна.




- Банкнуудын шинээр олгосон зээлийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 5 дугаар сард 17.2 хувь болж, өмнөх сараас 0.02 нэгж хувиар буурсан байна.
- Банкнуудын шинээр татсан хадгаламжийн жигнэсэн дундаж хүү 2025 оны 5 дугаар сард 11.9 хувь болж, өмнөх сараас 0.1 нэгж хувиар буурлаа.



Хөдөө аж ахуйн салбар сэргэж хөдөлмөрийн зах зээлийн өсөлтөд эергээр нөлөөлснөөр 2025 оны 1 дүгээр улиралд ажилчдын тоо 1 сая 380 мянга, ажиллах хүчний оролцооны түвшин 62.0 хувьд хүрлээ.



Өрхийн бодит орлогын өсөлт 5.8 хувьд хүрч саарав.





Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 1 дүгээр улиралд 266.1 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 25.2 мянгаар буюу 10.5 хувиар нэмэгдлээ.

НИЙТ БҮРТГЭЛТЭЙ ААН-ИЙН ТОО
(мянга, үйл ажиллагаа эрхлэлтээр)




- Бизнес регистрийн санд бүртгэлтэй нийт ААН-ийн тоо 2025 оны 1 дүгээр улиралд 266.1 мянгад хүрч өмнөх оны мөн үеэс 25.2 мянгаар буюу 10.5 хувиар нэмэгдлээ.
- Уг өсөлтийн 18.3 мянгыг үйл ажиллагаа эхлээгүй буюу шинээр байгуулагдсан ААН-үүд бүрдүүлсэн бол 7.9 мянгыг үйл ажиллагаа явуулж буй ААН-үүд бүрдүүллээ.
- Үйл ажиллагаа явуулж буй болон шинээр байгуулагдсан ААН-ийн тоо нэмэгдэж байгаа нь бизнесийн үйл ажиллагаа идэвхжиж байгааг илтгэж байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТООНЫ ӨӨРЧЛӨЛТ
(ААН-ийн тоо, салбараар)




- Дотоодын эдийн засаг идэвхжиж, худалдан авах чадвар сайжирснаар худалдаа, үйлчилгээний салбарт үйл ажиллагаа явуулж буй ААН 4.6 мянгаар нэмэгдлээ.
- Мөн хөдөө аж ахуйг дэмжих бодлого хэрэгжүүлсэн зэрэгтэй холбоотойгоор тус салбарын үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн тоо 49 хувиар өссөн байна.

ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БАЙГАА ААН-ИЙН ТОО
(мянга, ажиллагчдын тоогоор)



- Үйл ажиллагаа явуулж буй 109.8 мянган ААН-ийн 94.8 мянга нь бичил буюу 1-9 ажилтантай ААН-үүд байна.
- Мөн 1-9 ажилтантай ААН-үүд үйл ажиллагаа явуулж буй ААН-ийн өсөлтийн 92 хувийг бүрдүүлж байна.

ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС
(улирлаар, 2018=100)



- Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) 2025 оны 1 дүгээр улиралд 104.4-д хүрч өмнөх оны мөн үеэс 4.6 нэгжээр сайжирлаа.
- ХИИ-ийг задлан харвал хэрэглэгчдийн эдийн засгийн одоогийн нөхцөлийн үнэлэмжийг харуулдаг Өнөөгийн байдлын индекс өмнөх оны мөн үеэс 19.6 нэгжээр нэмэгдсэн. Үүнд хэрэглэгчдийн ажлын олдцын үнэлэмж сайжирсан нь нөлөөллөө.
- Харин эдийн засгийн ирэх 6 сарын хүлээлтийг харуулдаг Ирээдүйн хүлээлтийн индекс 0.2 нэгжээр буурсан бөгөөд үүнд бизнесийн нөхцөлийн хүлээлт муудсан нь нөлөөллөө.



ОХУ-ын эдийн засаг 2025 оны эхний улиралд 1.4 хувиар өслөө. Инфляцын түвшин 2025 оны 5 дугаар сард 9.9 хувьд хүрч, өмнөх сараас 0.4 нэгж хувиар буурлаа.




ОХУ-ын эдийн засгийн өсөлт 2025 оны 1 дүгээр улиралд 1.4 хувьд хүрч, өмнөх оны мөн үеэс 4 нэгж хувиар буурлаа.



2025 оны 4 дүгээр сарын байдлаар экспорт 33 тэрбум ам.доллар, импорт 24 тэрбум ам.долларт хүрч, худалдааны тэнцэл 9 тэрбум ам.долларын ашигтай байна.

Экспорт 2025 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 2.9 хувиар буурлаа.


Импорт 2025 оны 4 дүгээр сард өмнөх оны мөн үеэс 7.8 хувиар өслөө.



ОХУ-ын инфляц зорилтот түвшин болох 4 хувиас өндөр хэвээр байна.

Инфляцын түвшин 2025 оны 5 дугаар сард 9.9 хувь болж, өмнөх сараас 0.4 нэгж хувиар буурсан ч өмнөх оны мөн үеэс 1.6 нэгж хувиар өссөн байна.

ОХУ-ын төв банкнаас 6 дугаар сарын 6-ны өдөр бодлогын хүүг 1 нэгж хувиар бууруулж, 20 хувьд хүргэх шийдвэр гаргасан.




Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерүүдийн индекс (PMI) 2025 оны 5 дугаар сард 50.2 болж, өмнөх сараас 0.9 нэгжээр өслөө.

Аж үйлдвэрлэлийн бодит өсөлт 2025 оны 5 дугаар сарын байдлаар -0.2 хувь болж, өмнөх сараас 0.8 нэгж хувиар буурлаа.



2025 оны 5 дугаар сард БНХАУ-ын экспортын өсөлт саарч, импортын агшилт тэлсэн бол жижиглэний худалдааны өсөлт 6.4 хувьд хүрч эрчимжлээ.




- БНХАУ-ын эдийн засаг 2025 оны эхний улиралд 5.4 хувиар өслөө.
- Экспортын өсөлт 2025 оны 5 дугаар сард 4.8 хувьд хүрч саарсан бол импортын агшилт 2025 оны 5 дугаар сард 3.4 хувьд хүрч тэллээ.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.




- Аж үйлдвэрийн гарцын өсөлт 2025 оны 5 дугаар сард 5.8 хувьд хүрч, өмнөх сараас 0.3 нэгж хувиар саарав.
- Хэрэглээний төлөвийг илэрхийлэх жижиглэн худалдааны өсөлт 2025 оны 5 дугаар сард 6.4 хувьд хүрч эрчимжлээ.

Тэмдэглэл: Оны эхний 2 сарын статистик нэгтгэгдэн зарлагдаг.



- Хэрэглээний үнийн индексийн өөрчлөлт 2025 оны 5 дугаар сард -0.1 хувь болж, 3 сар дараалан ижил түвшинд хадгалагдлаа.
- Үйлдвэрлэгчийн үнийн индексийн өөрчлөлт 2025 оны 5 дугаар сард -3.3 хувь гарч, үнийн уналт үргэлжиллээ.



- Аж үйлдвэрийн салбарын худалдан авалтын менежерийн индекс 2025 оны 5 дугаар сард 49.5 болж, агшилтыг илэрхийлсэн хэвээр байна.
- Аж үйлдвэрийн бус салбарын болон нэгдсэн худалдан авалтын менежерийн индексүүд тэлэлтийг илэрхийлэх 50-аас дээш түвшинд хадгалагдаж байна.

Тэмдэглэл: Тус индекс нь богино хугацааны идэвхжилтийг илэрхийлэх бөгөөд ААН-үүдийн худалдан авалт, үйлдвэрлэл, ажил эрхлэлт, түүхий зэргийн нөөц зэвэг зүүллэлтийн талаарх аж үйлдвэрийн салбарын 3200 судалгаа, аж үйлдвэрийн бус салбарын 4300 судалгаанд үндэслэн сар бүр тооцдог. Индексийн 50-аас дээш утга нь тэлэлтийг, 50-аас доош нь агшилтыг илэрхийлнэ.



ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯАМ